



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

201 /201/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.12.15

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

Түүхэнд энэ өдөр

1921 он.

ХУРАНДАА ЦОЛ ОЛГОВ

АЖЛЫН ХЭСГИЙН ХУРАЛДААНААР ...



ЗХЖШ-ын даргын тушаалаар эрхэлсэн албандаа үр бүтээлтэй ажилласан зарим дэд хурандаа нарт албан тушаалын зэрэглэлийн хурандаа цол олголоо. Тодруулбал, Зэвсэгт хүчний ХЗЦК-ын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга дэд хурандаа С.Жаргалсайхан, КАБЦК-ын Төлөвлөлтийн хэлтсийн ажиллагааны төлөвлөлтийн ахлах, холбогч офицер дэд хурандаа Ж.Баттөмөр, Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн захирагч-байр зүйн албаны дарга дэд хурандаа Б.Даваа-Очир, ХХЕГ-ын Хилийн хэлтсийн дарга дэд хурандаа Д.Дугаржав, Кибер Аюулгүй байдлын хэлтсийн дарга дэд хурандаа Ж.Ганбаяр, Хилийн 0285 дугаар ангийн захирагч дэд хурандаа Г.Мөнгөншагай, Булган аймгийн Онцгой байдлын газрын улсын нөөц тусламжийн

01 дүгээр ангийн захирагч дэд хурандаа Н.Мөнхболд, ДХИС-ийн Удирдлагын академийн аюулгүй байдлын удирдлага, стратегийн профессорын багийн профессор дэд хурандаа Г.Лхагвамаа нарт хурандаа цол олгосон юм.

Энэ үеэр ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг шинэхэн хурандаа нарт баяр хүргэж хэлсэн үгэндээ "Хурандаа хэмээх энэ эрхэм цолыг хүртэхэд таны албаны төлөө хүчин чармайлт, хичээл зүтгэл, хамт олон, гэр бүлийн тань дэмжлэг байгаа. Цол хүртэхээс илүү цолныхоо нэр хүндийг даана гэдэг хамгийн том шалгуур үзүүлэлт. Үүрэг хариуцлага, ачаа даах чадвараараа бусдадаа үлгэрлэж, харилцаа, хүндлэлээрээ хамт олондоо үнэлэгдэх учиртай юм шүү. Та бүхний цаашдын ажил, албанд өндөр амжилт хүсье" гэсэн юм.

ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон Зэвсэгт хүчний 2021 оны шилдгүүдийг шалгаруулах ажлын хэсгийн анхдугаар хуралдааныг энэ сарын 14-ний өдөр зохион байгуулав.

Тус хуралдаанаар Зэвсэгт хүчний 2021 оны тэргүүний хамт олон, албан тушаалтнууд, оны бүтээлч болон онцлох ажлуудыг шалгаруулах тухай асуудлыг хэлэлцэж, нэгдсэн ойлголтод хүрлээ. Хуралдаанаар энэ онд дараах шилдгүүдийг тодруулахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

- 1.Зэвсэгт хүчний Тэргүүний анги;
- 2.Зэвсэгт хүчний Тэргүүний салбар;
- 3.Зэвсэгт хүчний Тэргүүний офицер;
- 4.Зэвсэгт хүчний Тэргүүний ахлагч;
- 5.Зэвсэгт хүчний Тэргүүний ажилтан албан хаагч;

- 6.Зэвсэгт хүчний Тэргүүний гэрээт цэргийн алба хаагч;
- 7.Зэвсэгт хүчний Тэргүүний шинийг санаачлагч;
- 8.Зэвсэгт хүчний Тэргүүний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч.

Энэ оны хувьд Зэвсэгт хүчний тэргүүний шинийг санаачлагч болон тэргүүний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгч номинацийн эзнийг шинээр шалгаруулна. Тодотговоос, Зэвсэгт хүчинд техник, технологи, инновацийн чиглэлээр шинэ бүтээл санаачлан бүтээсэн хамт олон, төв, алба хаагчдаас Зэвсэгт хүчний Тэргүүний шинийг санаачлагчийг шалгаруулах бол Тэргүүний төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчид улс орныг хөгжүүлэх, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хадгалах, сэргээх, хүн ардын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр төсөл, хөтөлбөр боловсруулсан эсвэл идэвх зүтгэлтэй оролцсон хамт олон, алба хаагчийг онцлох ажээ.

Хурандаа Б.ОТГОНБАЯР




СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Зэвсэгт хүчний 303 дугаар анги

Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг "Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар"-ын дэмжлэгтэй "Хүүхэд хамгааллын явуулын үйлчилгээ"-г үзүүлэх ажлын хүрээнд "Монгол Өрх" сэтгэл зүйн хүрээлэнгийн сэтгэл зүйч Д.Ууганцэцэгээр ахлуулсан баг бие бүрэлдэхүүнд энэ сарын 13-ны өдөр "Гэр бүл, хүүхэд хүмүүжил", "Хүүхэд хүмүүжлийн хортой 10 арга", "Хүүхэд хүмүүжлийн эерэг 10 арга", "Аз жаргалтай гэр бүлийн 6 дүрэм" зэрэг сэдвээр сургалт зохион байгууллаа. Тус сургалт нь эцэг, эхчүүд хүүхдүүдтэйгээ эерэг харилцаж, зөв хүмүүжил олгох талаар зөвлөгөө өгсөн үр дүнтэй сургалт болж өндөрлөв.

Ахмад Б.НАРАНБААТАР



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
374.040 +296

ВАКЦИНЖУУЛАЛТ
2,156,656 +532

НАС БАРСАН
1,965 +2

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6734 +112

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
159

ЭДГЭРСЭН
6446

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 271,097,024

Эдгэрсэн
Нийт: 243,754,350

Нас барсан
Нийт: 5,328,507

Энэ өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, угаал үйлдэх, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулаах, нарийн зөвлөгөөн хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсад баруун койш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДОРНЫН ЗУРХАЙ:
Үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд ЭЕРЭГ сайн

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-14	-33

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,844.0	2,851.0
EUR	3,179.0	3,250.0
CNY	445.30	448.60
RUB	38.10	39.50
JPY	24.77	25.36
KRW	2.36	2.45

ЗУРХАЙ

2021.12.15 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 12/

ӨВЛИЙН ДУНД ЦАГААН ХУЛГАНА САРЫН НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ТАХИА ӨДӨР

Үс ЗАСУУЛБАЛ:

Өвчин эмгэг ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.35-17.00

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Сансар

Суудал:

Уул

Энэ өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, угаал үйлдэх, хагалгаа хийлгэх, гэр бүрэхэд сайн. Мод суулаах, нарийн зөвлөгөөн хийхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсад баруун койш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ДОРНЫН ЗУРХАЙ:
Үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд ЭЕРЭГ сайн

ЦЭРЭГ-ЭХ ОРОНЧ ХҮМҮҮЖИЛ ОЛГОХ ТАНХИМ БАЙГУУЛЛАА



Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд Цэргийн штабын санаачлагчаар Арвайхээр хотын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2021 онд ашиглалтад орсон шинэ хичээлийн байрны ахлах бүлгийн түүх-нийгмийн тухай мэдлэгийн хичээлийн танхимыг хүүхэд багачуудад цэрэг-эх оронч хүмүүжил

олгох зориулалтаар тохижууллаа. Аймгийн хэмжээнд цэрэг-эх оронч хүмүүжил олгох дөрөв дэх танхимыг тохижуулж байгаагаараа онцлог бөгөөд нээлтийн арга хэмжээнд аймгийн Засаг даргын орлогч И.Доржсүрэн, Цэргийн штаб, аймгийн Боловсрол, соёл урлагийн газар, Арвайхээр хотын ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн удирдлага, багш нар болон зарим эцэг эхийн төлөөлөл, сурагчид оролцлоо.

Танхим нь эх орны бахархалт баатрууд, монгол цэргийн түүхэн замналыг харуулсан болон Өвөрхангай аймгаас төрсөн цэргийн алдартнуудын үйл ажиллагааг сурталчилсан хэсгүүдээс бүрдсэн. Мөн хүүхдүүдийн сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, багшийн хөгжлийг дэмжиж зорилгоор хэвлэх төхөөрөмж, оньсон болон хөлөгт тоглоом, түүх, нийгмийн тухай хичээлийн холбогдолтой үзүүлэн самбаруудыг байрлуулсан.

Түүнчлэн тус сургуулийн түүх-нийгмийн ухааны секцийн багш, сурагчид, цэргийн штабын офицерууд хамтран тохижуулж, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн хөлбэрээр орлуулан хаасан орлогыг орон нутагт үлдэх зардлаас шаардагдах хөрөнгийг шийдвэрлэсэн юм. Цаашид

энэ оны 12 дугаар сард багтаан Хайрхандулаан сумын ЕБС-ийн ахлах бүлгийн түүхийн хичээлийн танхимыг цэрэг-эх оронч хүмүүжил олгох танхим болгохоор тохижилтын ажлыг хийж, шаардагдах зардлыг аймгийн ЗДТГ, зарим сумдтай хамтран шийдвэрлэж байна. Тус аймгийн Цэргийн штаб

нь ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад цэрэг-эх оронч хүмүүжил олгох танхимуудыг үе шаттайгаар байгуулж, эх оронч хүмүүжил олгох орчин нөхцөлийг нэмэгдүүлэхэд анхааран ажиллаж байна.

Хошууч Ч.ВАНЧИНСҮРЭН

ХОВДЫН ХОРООНЫ АЛБА СУРТАЛЧЛАХ АЯН



Зэвсэгт хүчний 123 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилд алба, салбар сурталчлах аяны хүрээнд Захиргааны удирдлагын тасаг дараах ажлуудыг төлөвлөн зохион байгуулж байна. Тус аян байнгын бие бүрэлдэхүүнийг мэдлэг мэдээллээр хангах зорилгоор Ховд аймгийн "Музей"-ын мэргэжилтэн н.Ширнэн-Норов "Толбо нуурын тулгаралт"-ын талаар яриа таниулга хийсэн юм.

Үргэлжлүүлэн Шүүхийн Байгууллагаас Шүүхийн албаны дарга н.Даваасүрэн, Шүүгч н.Оюунгэрэл нар "Байгууллагын соёл", "Харилцааны соёл", "Монголын түүх" сэдвүүдээр сонирхолтой яриа, таниулга хийж бие бүрэлдэхүүнтэй уулзалт зохион байгуулав. Мөн байнгын бие бүрэлдэхүүний дунд "Чанга шивнээ" хөгжөөнт тэмцээн, гар бөмбөгийн аварга шалгаруулах

тэмээнийг үе шаттайгаар зохион байгууллаа. Тус тэмцээнүүдэд бие бүрэлдэхүүн идэвх санаачлагатай оролцож тэмцээний ялагчаар инженерийн албаны ахлагч Б.Болормаа, ахлагч Б.Мөнхтулга нар тэргүүлж хувцасны албаны ахлагч Б.Батзориг, дэд ахлагч Амгалан нар удаах байранд шалгарсан бол гар бөмбөгийн аварга шалгаруудах тэмцээнд холбоо, зэвсгийн алба, мотобуудлагын батальоны баг тамирчид тэргүүлэв.

Алба, салбар сурталчлах аяны хүрээнд Захиргааны удирдлагын тасаас цэргийн гэрээт алба хаагч болон ХЦАХ-ын дунд "АХА" асуулт хариултын тэмцээн, "Нэг хором нэг минут" хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулж явууллаа. Уг тэмцээнд цэргийн алба хаагчид идэвхтэй оролцож "АХА" асуулт хариултын тэмцээнд зенит артиллерийн батарейны байлдагч С.Намсрай, мотобуудлагын ротын байлдагч П.Пүрэвбаатар,

"Нэг хором нэг минут" тэмцээнд уулын хөнгөн ротын байлдагч Э.Лхагвацэрэн нэр бусдыгаа манлайлаа. Алба сурталчлах долоо хоногийн аяны төгсгөлд бие бүрэлдэхүүний соёлын хэрэгцээг хангах зорилгоор ангийн бүх эмэгтэй цэргийн алба хаагчид, хугацаат цэргийн алба хаагчидтай хамтран "Хослон дууль" дүэт дууны уралдааныг зохион байгуулсан юм. Уралдааны тэргүүн байранд талх

баригч Д.Цэрэндулам, артиллерийн батарейны байлдагч Б.Энхбат, дэд байранд холбооны нууцалсан хэрэгслийн баримт бичгийн техникч, няравахлагч Н.Нарандулам артиллерийн батарейны байлдагч Г.Билгүүн нар шалгасан бол гутгаар байранд сав угаагч Б.Эрдэнэбилэг, мотобуудлагын ротын байлдагч М.Нагсбай нар байр эзэлж авьяас чадвараараа өрсөлдлөө.

Ахмад У.БАТЦЭНГЭЛ

